

## НИЙСЛЭЛИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН АРХИВЫН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

### ХӨМРӨГ ҮҮСГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

1930 оны сүүлчээр хотын төвийн хэсгийг шинэчлэн байршуулах анхны зураг төлөвлөгөөг гаргаж зарим хуучин хашаа байшинг буулгаж дан давхар барилга барих гудамж талбайг засварлах, цардмал зам тавих зэрэг ажил эхэлсэн.

1953 онд ЗХУ-ын Москва хотын Гипрогор зураг төслийн байгууллага мэрэгжилтэнүүд уригдан ирж Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах судалгааны ажил хийж анхны ерөнхий төлөвлөгөөг 1953-1954 онд боловсруулагдсан.

Сайд Нарын Зөвлөлийн 1961 оны 417 дугаар тогтоолоор уг ерөнхий төлөвлөгөөг баталж Улаанбаатар хотын төлөвлөлт барилгажилтын үндсэн асуудлыг шийдвэрлэн эдгээр ажлыг эмх журамтай гүйцэтгэх, нийслэл хотын дэвсгэр нутагт байгуулах, их бага ямар нэгэн барилга байгууламжийн ажлыг хотын архитектурын газрын зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэж байхыг яам, тусгай газарт даалгажээ.

Энэ шийдвэрийн үндсэн дээр Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1961 оны 341 тоот захирамжаар хотын архитектурын газрыг 12 нэгж орон тоотойгоор байгуулсанаар хот төлөвлөлтийн байгууллагын хөгжлийн эхэн үе эхэлж батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны хороолол, үйлдвэрийн районуудыг барилгажуулах, зураг төслийн даалгавар боловсруулах, барилга байгууламжуудад газар олгох, геодезийн зураглал хийлгэх, улаан шугам тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэж байжээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1964 онд 7 дугаар сарын 15-ны өдөр 342 дугаар тогтоолоор “Барилгын засвар, шугам сүлжээний зураг төсвийн групп”-ийг жилд дунджаар 200-аад мянган төгрөгний төлөвлөгөөтэй, 10 нэгж орон тоотойгоор, нийслэл хотын барилгажилт түүний засварын ажлын хэмжээ ихээхэн өссөнтэй холбогдуулан Сайд нарын Зөвлөлийн 1968 оны 12 сарын 20-ны өдрийн 424 дүгээр тогтоолоор уг группийг Зурагтөсвийн товчоо болгон өргөтгөж 48 нэгж орон тоотой байгуулжээ.

Сайднарын Зөвлөлийн 1975 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 104 тогтоолоор хотын гүйцэтгэх захиргааны архитектурын газар, барилга захиалагчийн товчоо, барилгын зураг, төсвийн товчоог нэгтгэн Улаанбаатар хотын Барилга-Архитектурын газар болгон зохион байгуулжээ.

Хот байгуулалтын үзэл баримтлал, бодлогыг хэрэгжүүлэх нийслэл шинжлэх ухааны үндэстэйгээр хөгжүүлэх зорилгоор, нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурлын 1997 оны 10 дугаар сарын 23-ний өдрийн А-265 тоот захирамжийн шийдвэрийг үндэслэн “Зураг төсөл компан”-ийг нийслэлийн бүс нутгийн хөгжил, газар зохион байгуулалт, Улаанбаатар хот болон дагуул хот алслагдсан дүүргүүдийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол шинэчлэлтийн болон барилгын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, болон бусад хот байгуулалтын зураг төсөл болон хөтөлбөрүүдийг боловсруулах үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын дэрэгдэх “Хот байгуулалтын хүрээлэн” болгон 1998 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулахаар өөрчлөн зохион байгуулж

Монгол улсын засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн Засаг Даргын 2001 оны 01 сарын 09-ны өдрийн 23 тоот захирамжаар эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх үүрэг нэмэгдэж “Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэн” болгож өөрчлөн ажиллах дүрмийг нь батлажээ.

## ХӨМРӨГИЙН ТҮҮХ

Хөмрөгийн дугаар: 1  
Баримтын оны хязгаар: 1954-2012  
Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн данс: 1954-2012 оны..... ХН

### Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнгийн нэрийн өөрчлөлт

д/д	Дээд газрын шийдвэрийн нэр, огноо, дугаар	Нэрийн өөрчлөлт
1	Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1961 оны 341 тоот захирамж	Хотын архитектурын газар
2	БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1964 оны 7 сарын 15-ны өдөр 342 тогтоол	“Барилга засварын, төсвийн групп”
3	Сайд нарын зөвлөлийн 1968 оны 12 сарын 20-ны өдрийн 424 тогтоол	“Зураг төсвийн товчоо”
4	БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1975 оны 2сарын 27-ны өдрийн 104 тогтоол	Улаанбаатар хотын Барилга-Архитектурын газар
5	БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1978 оны 9сарын 11-ны өдрийн 294 тогтоол	Улаанбаатар хотын Архитектур төлөвлөлтийн газар
6	Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1990 оны тогтоол	“Зураг төслийн товчоо”
7	Монгол Улсын засгийн газрын 1997 оны 4сарын 30-ны өдрийн 108 тогтоол	“Зураг төсөл компани”
8	Монгол Улсын нийслэлийн засаг даргын 1997 оны 10сарын 23-ны өдөр А-265 захирамж 1998 оны 1сарын 1-ээс	“Хот байгуулалтын хүрээлэн”
9	Нийслэлийн засаг даргын 2000 оны 12сарын 21-ний 456 тоот захирамж	“Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэн”
	Монгол Улсын засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2009 оны 02сарын 04-ний өдөр 13 тогтоол	Хүрээлэнг татан буулгасан
10	Нийслэлийн засаг даргын 2009 оны 2 сарын 13 өдөр 52 захирамж	Барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газарт шилжсэн
11	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2010 оны 03сарын 31-ний өдрийн 50 тогтоолоор	“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн”

2004 оны 02 сард Барилга байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичигт эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийж 1969-1979 оны 737 хадгаламж нэгжид данс бүртгэл үйлдэж Үндэсний төв архивын дэрэгдэх БНШАЗК-ын 2004 оны 08 сарыг 16 өдрийн хурлаар хянан хэлэлцэж Протокол № 02 Шинжлэх ухаан технонолги зураг төслийн архивт шилжүүлсэн. Хот байгуулалтын хүрээлэн үүсгэн байгуулагдсан цагаас хойш баримтанд ЭШТБ-ын ажлыг 2008 оны 12 сарын 26-наас 2009 оны 01 сарын 10-ний өдрийг хүртэл хугацаанд Нийслэлийн Архивын Газартай гэрээ хийж арга зүйч Баттогтох удирдлагын цаасан суурьтай баримт бичигт нягтлан шалгалт хийж гүйцэтгээд байнга, түр хадгалах, устгах зэргээр ялган ангилан төрөлжүүлсэн. Эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийж 1995-2007 оны захирлын тушаалыг “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу байнга, 70 жил хадгалахаар ангилан 26 хадгаламж нэгж тус бүрт дотоод товъёог үйлдсэн. Байнга хадгалах хадгаламжийн данс 1995-2007 он хүртлэх 28 хадгаламж нэгж, түр хадгалах хадгаламжийн данс 1998-2007 он хүртлэх 126 хадгаламж нэгж, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл 1995-2007 он хүртлэх 37 хадгаламж нэгж, устгах хэргийн акт 1995-1999 он 13 хадгаламж нэгжийг Нийслэлийн Архивын Газрын

ББНШАЗК-ын 2009 оны 12 сарын 20-ны өдрийн хурлаар мөн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос үүссэн 1954-2008 оны 630 зураг төслийн баримт бичгийг он дарааллаар нь жагсааж данс бүртгэл үйлдэжтүс тус батлагдсанбүртгэлтэй болсон.НийслэлийнИргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 03 сарын 31-ний өдрийн 50 дугаар тогтоолоор “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн”-г дахин байгуулагдаж Үйл ажиллагаанаас үүссэн баримт бичгийг он цаг болон нэр төрлөөр ангилан төрөлжүүлж зориулалтын өрөөнд хадгалж байгаад .

Байнга хадгалах 2008-2010 оны 14 ХН  
Түр хадгалах 1998-2010 оны 140 ХН  
70 жил хадгалах 1995-2010 оны 47ХН  
Устгах хэргийн акт 2000-2001 оны 21 ХН  
Зураг төслийн 1970-2010 оны - 232 ХН

Дискний бүртгэл 2004-2010 оны 273 ХН-ийн бүртгэлийг НАГ-ын ББНШАЗК-ын 2011 оны 12 сарын 20-ний өдрийн 04-р хурлаар тус тус хэлэлцүүлсэн.

Одоогийн байдлаар хувь хүмүүсийн баримт хадгалагдаагүй байна. Баримтанд тоолго хийхдээ даргын тушаалаар ажлын хэсгийг батлажудирдамжийг танилцуулан баримтын бүртгэлийн дарааллаар тооллогын гишүүд хуваан авч тооллоод арын хуудсанд “тоолов” гэсэн бичилтийг хийгээд тооллогын гишүүдээс тус бүрээс нь мэдээг аваад нэгтгэсэний үндсэн дээр дүн мэдээг илтгэх хуудасны хамт хүргүүлсэн.

### **ХӨМРӨГИЙН БАРИМТ**

Барилга байгууламжын засвар, өргөтгөлийн зураг төсөв, дотор, гадна дулаан, цахилгаан, цэвэр бохир ус, дотор халаалт гэх зэрэг холболтын зураг, худгийн барилга, засварын цех, мужааны цех, конторын өргөтгөл, ус хангамж, цахилгааны холболт ажлыг гүйцэтгэж байжээ. Нийслэлийн зураг төслийн хүрээлэнд ирсэн Нийслэлийн Засаг Даргын захирамж, тогтоолын хуулбар хувь, товчоон даргын тушаал, цалин тавьж олгосон хүснэгт, цалингийн карт, Хот төлөвлөлт эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэнгийн захирлын тушаал, хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ, Санхүүгийн хаалтын баланс, Нийслэлийн засаг даргын захирамж 246, 286, Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн даргын тушаал, захиргааны зөвлөлийн хурлын тэмдэглэл, ажлын төлөвлөгөө, тайлан, Нийслэлийн хүрээлэнгийн даргын ерөнхий менежертэй хийсэн үр дүнгийн гэрээ, тайлан, стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, хамт олны хурлын тэмдэглэл, хүрээлэнгийн 2011 оны Нийслэлийн нийгэм эдийн засгийн зорилтын биелэлт, хүрээлэнгийн тогтоол шийдвэрийн биелэлт, тушаал, ирсэн, явсан бичгийн бүртгэлийн дэвтэр, ирсэн, явсан бичиг, хөдөлмөрийн гэрээ, бэлэн мөнгө, кассын тайлан, Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банктэй харилцах дансны баримт,нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, үндсэн хөрөнгө, материалын тайлан, дансны хуулга, ажилчдаас ирсэн өргөдөл, хүсэлт, тойрох хуудас, ээлжийн амралт олгосон хуудас, ажил хүлээлцсэн акт, зөвхөн хүрээлэнд хийгдсэн ерөнхий төлөвлөгөөний ажилд зориулсан судалгааны материал, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тайлбар бичиг, тохижилтын зураг төсөв, авто замын зураг, төсөв, барилга байгууламжын ажлын зураг гэх баримтын бүрэлдэхүүнтэй.

Энэ хугацаанд Улаанбаатар хот 2020 он ерөнхий төлөвлөгөө болвсруулах эхний үе шатны суурь судалгааны ажлыг гүйцэтгэж Улаанбаатар хот 2020 он Ерөнхий төлөвлөгөө, орон сууцны 1,3,4,5,6,7,10,12,15,16-р хорооллууд, Өлзийт хороо,Тохилтын амны Амины орон сууцны хороолол, баруун бүсийн төв Ховд хот, төвийн бүс тулгуур төв Дархан хот, Ховд аймгийн Алтай сумын төвийн шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөө, Даланзадгад хотын ерөнхий төлөвлөгөө,Баруун өмнөд үйлдвэрийн район, Хотын шинэ төв, Чингисийн өргөн чөлөө, Алтан-Өлгий орчим, Амгалангийн зам дагуу, Олимп хотхоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар бүс, Багахангай, Багануур, Налайх дүүргүүдийн бүс нутгийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөр 2007-2008 онуудад Улсын болон нийслэлийн хөрөнгө оруулалтай 40-д авто замын зураг төсөв, мөн тендерээр хотын захын гэр хорооллын /3-7 буудлын зам дагуух, 32-н тойруу/ хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Өмнөговь аймгийн Цогтцэций, Гурван тэс сумдын гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг, Өмнөговь аймгийн Ноён, Ханбогд, Цогт-Овоо, Баян-Овоо сумдын 04 кв-ын цахилгааны шугамын өөрчлөлтийн зураг, Хархорин Эрдэнэзуу орчмын аялал жуулчлалын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, Өмнөговь аймаг Цогт-Овоо,

Баяндалай, Баян-Овоо сумдын ерөнхий төлөвлөгөө, Тасганы овоо дахь Монгол үндэсний соёл шашны цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлын зураг зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Манай байгууллага Нийслэлийн хот төлөвлөлт эрдэм шинжилгээзураг төслийн хүрээлэн нь 889 хадгаламж нэгжтэй /1954-2008 он/ Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тайлбар бичиг, геологийн дүгнэлт, төсөв, удирдлагын цаасан суурьтай баримт бичиг /1998-2007 он/, /1995-2007 он/ 70 жил хадгалах хадгаламж нэгж, /1995-2007 он/ байнга хадгалах хадгаламж нэгжтэй.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн 55 га нэгж талбайн тохижилтын зураг төсөв, Дархан хотын үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын зураг, Хотын захын гэр хорооллыг дахин төлөвлөх загвар төсөл, Сүхбаатар дүүрэг 1-р хороо Клиникийн нэгдүгээр амаржих газрын барилгын их засварын зураг, төсөв, Сүхбаатар дүүрэг 13-р хорооны Жижиг дунд үйлдврийн барилга, Далан давхар буюу Самбалхүндэв оршуулгын газрын хашаа, төсөв, төлбөртэй болон тусгай зориулалтын авто зогсоолын тохижилтын ажлын зураг, төсөв, дүүргүүдийн орон сууцны байрнуудын дундах бичил цэцэрлэг тохижилтын ажлын зураг, ганди, анкарагийн гудамжны тохижилт, Замын-Үүдийн эдийн засгийн мастер төлөвлөгөө, 3-7 буудал хороолол, 32-ын тойрог орчмын ерөнхий төлөвлөгөө, Танан импекс ХХК-ийн оффис, үйлчилгээ, гаражийн барилга, Майхан толгой-2 0.65 км авто замын ажлын зураг, Баянхошуу, Дэнжийн 1000, Улиастай, Шархад, Нисэхийн автобусны эцсийн буудлын цогцолбор баригын зураг, төсөв, Энхтайвны өргөн чөлөөний дагуух орон сууцны барилгын фасадыг шинэчлэх зураг төсөв, Багануур дүүргийн 3-р хороо Боулин, Усан спорт сургалтын төвийн барилгын зураг төсөв, Баянгол дүүрэг 7-р хороо Усан спорт сургалтын төвийн барилга, Сонгинохайрхан дүүргийн Усан спорт сургалтын төвийн барилга, Хан-Уул дүүргийн 9-р хороо Усан спорт сургалтын төвийн барилга, Чингэлтэй дүүрэг 1-р хороо хонгилын системийн зураг төсөв, Сүхбаатар дүүрэг Бэлх-Сэлхийн чиглэлийн 4.5км авто замын зураг төсөв, Тасганы-Овоон метал явган гүүрийн ажлын зураг, 10 байршилтай таксины зогсоолын ажлын зураг төсөв, Их тойруугаас Арслантай гүүр хүртлэх тохижилт, усны байгууламжийн тохижилт, Дэнжийн-1000-ын гахайн байраас суурьшлын бүс хүртлэх 1.21 км авто замын ажлын зураг төсөв, Баянгол дүүрэг Спорт цогцолборын барилга, Багануур дүүргийн 20,21,22,26,27-р байрны дундах бичил цэцэрлэгийн тохижилтын зураг төсөв, Энхтайвны гүүр, Яармаг, Сонсголонгийн, Зайсангийн гүүрний урсгал засварын тохижилтын зураг төсөв, Чингэлтэй дүүрэг Хүүхдийн номын сантай хорооны цогцолбор барилгын нэг маягийн зураг төсөл, иргэн Энхийн оффис үйлчилгээний барилгын зураг, 3,4-р хорооллын 2-р ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Зуслангуудын ерөнхий төлөвлөгөөг зэрэг ажлуудыг боловсруулан гүйцэтгэж хийсэн ба “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол” 2030 он хүртлэх хөгжлийн чиг хандлага боловруулагдаж дуусаад байна.



## НИЙСЛЭЛИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН

Хөмрөгийн дугаар:  
Баримитын оны хязгаар:  
Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн данс:

Улаанбаатар хот  
№  
1954-2009  
1954-2008 оны 699 ХН  
3%

### Хөмрөг үүсгэгчийн нэрийн өөрчлөлт

Д/д	Нэрийн өөрчлөлт	Огноо
1	Барилга засвар шугам сүлжээний зураг төсвийн групп	1964
2	Зураг төсвийн товчоо	1968
3	Улаанбаатар хотын Барилга Архитектурын газар	1975
4	Улаанбаатар хотын Архитектур төлөвлөлтийн газар	1978-1990
5	Улаанбаатар хотын зураг төслийн товчоо	1990-1997
6	Улаанбаатар хотын "Зураг төсөл" компани	1997-1998
7	Хот байгуулалтын хүрээлэн	1998-2000
8	Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн	2001.01
9	Нийслэлийн барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газарт нэгтгэсэн	2009.02.13
10	Нийслэлийн зураг төслийн хүрээлэн	2010.03.31

Нэг: Хөмрөгийн түүх

1930 оны сүүлчээр хотын төвийн хэсгийг шинэчлэн байршуулах анхны зураг төлөвлөгөөг гаргаж зарим хуучин хашаа байшинг буулгаж дан давхар барилга барих гудамж талбайг засварлах, цардмал зам тавих зэрэг ажил эхэлсэн.

1953 онд ЗХУ-ын Москва хотын Гипрогор институтын мэрэгжилтэнгүүд уригдан ирж Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах судалгааны ажил хийж анхны ерөнхий төлөвлөгөөг 1953-1954 онд боловсруулагдсан.

Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 417 дугаар тогтоолоор уг ерөнхий төлөвлөгөөг баталж Улаанбаатар хотын төлөвлөлт барилгажилтын үндсэн асуудлыг шийдвэрлэн эдгээр ажлыг эмх журамтай гүйцэтгэх, нийслэл хотын дэвсгэр нутагт байгуулах, их бага ямар нэгэн барилга байгуулатжийн ажлыг хотын архитектурын газрын зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэж байхыг яам, тусгай газарт даалгажээ. Энэ шийдвэрийн үндсэн дээр Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1961 оны 341 тоот захирамжаар хотын архитектурын газрыг 12 нэгж орон тоотойгоор байгуулсанаар хот төлөвлөлтийн байгууллагын хөгжлийн эхэн үе эхэлж батлагдсан ерөнхий төлөвлөгөөний орон сууцны хороолол, үйлдвэрийн районуудыг барилгажуулах, зураг төслийн даалгавар боловсруулах, барилга байгууламжуудад

Ху-7

газар олгох, геодезийн зураглал хийлгэх, улаан шугам тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэж байсан.

1964 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор "Барилга засвар, шугам сүлжээний зураг төсвийн групп"-ийг жилд дунджаар 200-аад мянган төгрөгний төлөвлөгөөтэй, 10 нэгж орон тоотойгоор, нийслэл хотын барилгажилт, түүний засварын ажлын хэмжээ ихээхэн хэмжээгээр өссөнтэй холбогдуулан СнЗ-ийн 1968 оны тогтоолоор уг группийг аж ахуйн тооцоотой зураг төсвийн товчоо болгон өргөтгөж 48 нэгж орон тоотой, жилд дунджаар 1.2 сая төгрөгний төлөвлөгөөтэй, 500 мянган төгрөгийн ашигтай ажиллагаагаар байгуулсан. Уг товоо Улаанбаатар хотын дүүрэг дэх иргэний болон соёл, ахуй үйлчилгээний барилга байгууламжуудын барилга, сантехник, цахилгааны засварын болон реклам чимэглэл, зарим шинэ барилгын зураг төсөв зохиож байв. Нийслэл хот эрчимтэй барилгажин хөгжиж, орчин үеийн томоохон хот болон өргөжиж байсны улмаас дүүрэг болон төвийн шинэчлэн боловсруулсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын бодлого дэг журмыг тууштай сахиулах үүднээс Архитектурын газрыг өргөтгөн Сайд нарын зөвлөлийн 1975 оны 104 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын Барилга архитектурын газар, Сайд нарын зөвлөлийн 1978 оны 294 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын Архитектур төлөвлөлтийн газар болгон зохион байгуулж материаллаг бааз болон шинэ залуу боловсон хүчнүүдээр бэхжүүлж байв.

Хот төлөвлөлтийн барилгын хөгжил, ерөнхий төлөвлөгөөнийн дагуу барьж байгуулах хот байгуулалтын бодлого, дэг журмыг сахиулах ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих хүн амын нягтрал суурьшлыг зохистой шийдвэрлэж байсан.

Монгол Улсын Нийслэлийн Засаг даргын Захирамжаар Улаанбаатар хотын "Зураг төсөл" компанийг 1998 оны 1-р сарын 01-ний өдрөөс эхлэн, "Хот байгуулалтын хүрээлэн" болгон өөрчлөн зохион байгуулж аж ахуйн тооцоон дээр үйл ажиллагаа явуулж эхлэсэн ерөнхий захиралаар архитектор, дэд доктор Майдар овогтой Оргил томилогдсон.

Зохион байгуулалтын асуудалтай нягт холбоотойгоор нийслэлийн хот байгуулалт, бүс нутгийн хөгжил дэвсгэр нутгийн зохион байгуулалт Улаанбаатар хот түүний дагуул хаяа болон алслагдсан хот тосгодын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол шинэчлэлийн зураг төсөл ба дүүргүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах үндсэн чиглэлтэйгээр манай хүрээлэн байгуулагдсан юм.



үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд архитектор 2, геологийн инженер 1, аялал жуулчлалын мэргэжилтэн 1, эдийн засагч 2 хүн ажиллаж байгаа.

Хот байгуулалт, төлөвлөлтийн асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зах зээлийн шинэ нөхцөлд тохируулан судлах, төлөвлөх, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдах болсон. Монгол Улсын нийгэм эдийн засгийн шинэ нөхцөлд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот түүний бүс нутгийг XXI зуунд эрчимтэйгээр хөгжүүлэх зорилтыг агуулсан "Нийслэлийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр"-ийн хүрээнд нийслэлийн нийгэм эдийн засаг хүрээлэн буй орчны удирдлага зохион байгуулалтын асуудалтай нягт холбоотойгоор нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлтийн асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зах зээлийн шинэ нөхцөлд тохируулан судлах, төлөвлөх, хэрэгжүүлэх шаардлага тавигдах болсон.

Одоогийн байдлаар тус хүрээлэн 40 гаруй ажиллагсадтай архитектур хот төлөвлөлт, бүс нутгийн хөгжил эрдэм шинжилгээ судалгааны 2 сектортой үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хугацаанд УБ хот 2020 он ерөнхий төлөвлөгөө болвсруулах эхний үе шатны суурь судалгааны ажлыг гүйцэтгэж УБ хот 2020 он Ерөнхий төлөвлөгөө, орон сууцны 1,3,4,5,6,7,10,12,15,16-р хорооллууд, Өлзийт хороо,Тахилтын амны АОС хороолол, баруун бүсийн төв Ховд хот, төвийн бүс тулгуур төв Дархан хот, Ховд аймгийн Алтай сумын төвийн шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөө, Даланзадгад хотын ерөнхий төлөвлөгөө,Баруун өмнөд үйлдвэрийн район, Хотын шинэ төв, Чингисийн өргөн чөлөө, Алтан-Өлгий орчим,Амгалангийн зам дагуу, Олимп хотхоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар бүс, Багахангай, Багануур, Налайх дүүргүүдийн бүс нутгийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөр зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Манай байгууллага Нийслэлийн зураг төслийн хүрээлэн нь

Нийт 889 хадгаламж нэгжтэй /1954-2008 он/ Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тайлбар бичиг, геологийн дүгнэлт, төсөв, удирдлагын цаасан суурьтай баримт бичиг /1998-2007 он /, / 1995-2007 он / 70 жил хадгалах хадгаламж нэгж, /1995-2007 он / байнга хадгалах хадгаламж нэгжтэй.

2007-2008 онуудад Улсын болон нийслэлийн хөрөнгө оруулалтай 40-д авто замын зураг, мөн тендерээр хотын захын гэр хорооллын /3-7 буудлын зам дагуух, 32-н тойруу / хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Өмнөговь аймгийн Цогтцэций,Гурван тэс сумдын гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг,Өмнөговь аймгийн Ноён, Ханбогд, Цогт-Овоо, Баян-Овоо сумдын 04 кв-ын цахилгааны шугамын өөрчлөлтийн зураг, төсвийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2009 оны 02 сарын 04-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын

52

тэргүүлэгчдийн №13 дугаар тогтоолоор бүтэц зохион байгуулалтыг шинэчилсэнтэй холбогдуулан Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнг Барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газартай нэгдэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байв.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2010 оны 03 дугаар сарын 31-ний өдөр 50 дугаар тогтоолоор бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр Нийслэлийн өмчит улсын үйлдвэрийн газар, Нийслэлийн зураг төслийн хүрээлэнг байгуулж даргаар С.Цахиур томилогдон Зураг төслийн хэлтэс, Төлөвлөлтийн хэлтэс, Тамгын хэлтэс, Хөгжлийн менежментийн 4 хэлтэстэй үйл ажиллагааны дүрэмд өөрөө өөрийгээ санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцооны үндсэн дээр Улсын үйлдвэрийн газрын эрхтэйгээр ажиллах болсон.

Тамгын хэлтсийн дарга А. Амарсайхан

Ерөнхий инженер Г.Нарангэрэл

1. Хуулийн зөвлөх А.Амарсайхан
2. Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Оргодол
3. Нябо О.Бямбасүрэн
4. Системийн мэргэжилтэн Баярбат
5. Даргын туслах бичиг хэрэг хариуцагч Мөнгөнтунгалаг
6. Эд хариуцагч Баасансүрэн
7. Архивын эрхлэгч Г.Тунгалаг

Зураг төслийн хэлтсийн дарга Л. Солонго

1. Ахлах мэргэжилтэн П.Батчимэг
2. Архитектор Б. Мөнхбат
3. Архитектор Н.Наранбат
4. Архитектор Хулан
5. Архитектор Баясгалан
6. Архитектор Г. Жасрай
7. Ландшафтны архитектор Хүрэлтушаа
8. Төсөвчин А.Чимэгээ
9. Замын инженер С. Жаргалсайхан
10. Барилгын инженер Ч. Амарзаяа
11. Зөвлөх инженер / замын / Однасан
12. Цахилгааны инженер Л.Эрдэнэбилэг
13. Дулааны инженер О.Заанхүү
14. Барилгын инженер Б.Мөнгөнсүх



15. Барилгын инженер Д.Төрбол
16. Архитектор Б. Байгал
17. Халаалт салхивчийн инженер Ш.Энжжаргал

Төлөвлөлтийн хэлтсийн дарга Л.Ганбат

1. Ахлах мэргэжилтэн Б.Тунгалаг
2. Архитектор П.Энхбаатар
3. Архитектор Г.Өлзийням
4. Архитектор О.Амарзаяа
5. Архитектор Б.Эрдэнэбулган
6. Архитектор Ш.Төмөрсүх
7. Геодезийн инженер Ш.Дуламсүрэн
8. Ариутгах татуургын инженер/зөвлөх/ М.Эрдэнэцэцэг
9. Дулааны инженер Д.Гэрэлээ
10. Газар зохион байгуулагч Г.Анхбаяр
11. Эдийн засагч Н. Эгиймаа
12. Эдийн засагч Ц.Мягмарсүрэн
13. Архитектор С.Баяртогтох
14. Цахилгааны инженер Г.Гансүх
15. Төслийн мэргэжилтэн Т.Хорлоо

Хөгжлийн менежментийн хэлтэс дарга Б.Баясгалан

Гадаад харилцааны мэргэжилтэн А. Харцага

Төслийн мэргэжилтэн Уранбайгаль

Төслийн мэргэжилтэн Ж.Болорчимэг

Тус хүрээлэн нь Замын-Үүдийн чөлөөт бүсийн техник эдийн засгийн мастер төлөвлөгөө, Хархорин Эрдэнэзуу орчмын аялал жуулчлалын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, Багахангай дүүрэг, Багануур дүүрэг, Налайх дүүрэг, Өмнөговь аймаг Цогт-Овоо, Баяндалай, Баян-Овоо сумын ерөнхий төлөвлөгөө, Тасганы овоо дахь Монгол үндэсний соёл шашны цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлын зураг, 1-р амаржих газрын барилгын их засварын зураг төсөв, Эх нялхасын эрдэм шинжилгээний хашаан дах Алдарт эх Норжмаагийн хөшөө, хөшөө орчмын тохижилтын ажлын зураг, Самбалхүндэвийн оршуулгын газрын хашааны ажлын зураг, дүүргүүдийн орон сууцны талбайн тохижилтын зураг төсөв, авто машины төлбөртэй 294 зогсоолын зураг боловсруулсан.

Хоёр: *Хөмрөгийн түүх* Тус хүрээлэн нь 2007 онд байгууллагын архивын өрөөг тусад нь байгуулж Нийслэлийн архивын газраас байгууллагын удирдлагын баримтанд

ЭШТБ-ын ажлыг 2008 оны 12 сарын 26-с хийж 1995-2007 оны 150 орчим хадгаламж нэгжид техник боловсруулалт хийж байнга, түр хадгалах баримт 1995-2007 оны байнга 28 хн, түр хадгалах 1998-2007 оны 126 хн, 70 жил хадгалах 37 хн, устгах хэрэг 1995-1998 оны 13 хэрг баримтыг устгалд ялган данс бүртгэл, актыг үйлдсэн. Тусгай төрлийн гэгдэх зураг төслийн баримт 1954-2008 оны 699 хадгаламж нэгжтэй. Зураг төслийн баримтанд данс бүртгэл үйлдэж Нийслэлийн архивын газрын БНШАЗК-ын хурлаар 2009 оны 12-р сарын 04-ний өдрийн 05 дугаар хурлаар хянан хэлцүүлсэн. Архивын ажилтан Г.Тунгалаг түүхчилсэн лавлахыг өмнөх үеийн тогтоол захирамжийн судалгаа хийж үзсэний үндсэн дээр архивын товч түүх нэртэй лавлахыг үйлдсэн болно. Бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх тохиолдолд тухайн бүр нэмэлт баяжилт хийж байна.